Монгол Данжуур дахь Аюурведийн анагаах ухааны зохиолуудыг тодруулан судлах асуудал

Л.Түдэвдагва[1], Б.Гэрэлмаа[2], Д.Шагдарсүрэн[1], Ш.Болд[1,2]

[1]Эм зүйн шинжлэх ухааны их сургууль
[2]"Ач" Анагаах ухааны их сургууль
Цахим шуудан: ltudevdagva@gmail.com, Утас: 99949345

Түлхүүр үг:

Данжуур
Аюурвед
Анагаах ухаан
Монгол орчуулагч

Товч утга:

Үндэслэл: Монгол Данжуур бол Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй, дэлхийд ховордсон 226 боть их хөлгөн судар бөгөөд Энэтхэг, Төвөдийн эрдэмтдийн бүтээлийг багтаасан баримт, мэдлэгийн чухал өв юм. Энэхүү сударт багтсан Аюурведийн 8 ном нь Монголд анагаах ухааны эртний мэдлэг түгэн дэлгэрч байсаны баталгаа болж, энэ салбарт гүнзгий судалгаа хийх шаардлагыг харуулдаг. Аюурведийн өвчнөөс сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих зорилго бүхий онол, арвин туршлага нь орчин цагийн анагаах ухааныг баяжуулах чухал эх сурвалж болно. **Зорилго:** Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж байгаа Монгол данжуур дахь Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны зохиолуудыг нэр, ботийн дугаар, хуудасны дугаарыг тогтоон, монгол орчуулагч нарыг нь тодруулан тайлбар хийх. **Арга, аргачлал:** Монгол шунхан Данжуур, тэр дундаа 118-123 дугаар ботид багтсан Аюурведийн анагаах ухааны зохиолуудыг ашиглав. Судалгаанд сурвалж бичгийн судлал болон магадлан жагсаах аргуудыг хэрэглэж, зохиолуудыг цаг хугацааны дарааллаар эрэмбэлэх, төрөлжүүлэн ангилах, эхний шатны үнэлгээ хийх ажлыг гүйцэтгэсэн**. Үр дүн:** Судалгаагаар Монгол Данжуурын анагаах ухааны бүтээлүүд нь Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны зохиолуудаас голлон бүтсэн бөгөөд энэ номын судалгаа сүүлийн үед эрдэмтдийн сонирхлыг татаж байна. Уг судалгаанд бид Монгол Данжуурын анагаах ухаантай хэрхэн холбогдож байгаа талаар болон хэрхэн соёлын өвийг хадгалан үлдсэн талаарх баримт материалуудыг судлан тодруулласа. **Дүгнэлт:** "Монгол Данжуур"-ын Судрын тайлбарын 118-123 дугаар ботид анагаах ухааны 8 зохиол байгааг тодруулан, нэр, ботийн дугаар болон хуудасны тоог дараах байдлаар тогтоов. Үүнд: 1. (4855) Зуун найралт (118-1) 2 до-14 дэ, 2. (4856) Амьдруулагч эмийн судар, (118-3) 14 дэ-20 до, 3. (4857) Ава эмийн зан үйл (118-3) 21 дэ-22 до, 4. (4858) Найман гишүүнтийн зүрхний хураасан нэрт (118-4) 23 дэ-527 до, 5. (4859) Найман гишүүнтийн зүрхэн хэмээх эм, заслын номлол (118-5) 527 до-119-р боть, 715 до, 6. (4860) Эм, заслын найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар үг, утгын сарны гэрэл хэмээх оршивой (120-1) 2 до-121-р боть, 476 до, 7. (4861) Эм, заслын найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар эмийн нэрийн зүйл хэмээх оршивой (122-1) 476 до-519 дэ, 8. (4862) Хамгийн эрхт шим авахуй хамаг өвчнийг дараад биеийн хүчийг дэлгэрүүлэгч хэмээгдэхүй. (123-1) 2 до-3 до гэсэн зохиолууд байв.

Үндэслэл: Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж буй хэвлэмэл шунхан Монгол Данжуур бол дэлхий дээр ганц хувь байгаа маш ховор бичгийн үнэт дурсгал юм. Ганжуурын тайлбар болох Монгол Данжуур (Зарлигийн орчуулга) сударнь 226 боть бөгөөд Энэтхэг, Төвөдийн эрдэмтэн мэргэдийн бичсэн их, бага арван ухааны шастирууд, 3427 нэр төрлийн ном зохиолыг багтаасан 107839-н хуудастай, 23х72.5см хэмжээтэй их хөлгөн судар юм. Энэхүү Монгол шунхан Данжуур-ыг Жанжаа хутагт Ролбийдорж,

Ширээт хутагт Лувсанданбийням тэргүүтэй 200 орчим гүүш төвөд хэлнээс монгол хэлнээ 1741-1742 онд орчуулж, 1742-1749 оны хооронд Бээжинд 226 боть болгон модон бараар хэвлэсэн олон хүний хамтын бүтээл болно[1].

Аюурвед гэдэг үг нь "Аюуш" буюу "Амьдрал", "Вед" нь "Шинжлэх ухаан" гэсэн хоёр санскрит үгийн нийлэмж бөгөөд үгчлэн орчуулбал "Амьдралын тухай шинжлэх ухаан" гэдэг утгатай юм. Энэ нь Энэтхэгт 5000 жилийн тэртээ үүссэн гэж үздэг.

Монгол Данжуурын дотор бурхны шашны судар, номууд гол суурийг эзлэх боловч уран зохиол, толь бичиг, хэлний зүй, гүн ухаан, газар зүй, анагаах ухаан зэрэг олон ухааны ном судар багтжээ. Энэхүү их хөлгөн судруудын 118-123 дугаар ботид Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны 8 ном орсон. Аюурвед бол орчин цагийн анагаах ухаантай эн тэнцүү бүтэц, зохион байгуулалттай, хамгийн эрт үеийн, баримт нотолгоо, ном бүтээл арвин салбар юм. Аюурведийн бүхэл цогцын онолд суурилсан тусламж үйлчилгээ нь хүн амын эрүүл амьдрах боломжийг бүрдүүлэхээс гадна нь өвчнийг эмчлэх талаараа ихээхэн туршлага хуримтлуулсан. Аюурведийн үндсэн зорилго нь өвчнөөс сэргийлэх, эрүүл мэндээ бататгахад оршдог. Аюурвед бол Энэтхэгийн хойгийн уламжлалт анагаах ухааны нэн эртний тогтолцоо билээ.

Эдгээр номуудын орчуулга нь Монголд Аюурведийн анагаах ухааны мэдлэг ухаан дэлгэрэн хөгжиж байсан, хөгжих боломжтой байсны баталгаа төдийгүй эдгээр бүтээлүүд тун бага судлагдсан байгаа нь бидний судалгааны үндэслэл боллоо.

Зорилго: Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж байгаа Монгол данжуур дахь Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны зохиолуудыг нэр, ботийн дугаар, хуудасны дугаарыг тогтоон, монгол орчуулагч нарыг нь тодруулан тайлбар хийх.

Арга, аргачлал:

Судалгааны хэрэглэгдэхүүн: Монгол Улсын Үндэсний номын санд хадгалагдаж байгаа 226 боть Монгол шунхан Данжуур, түүний 118-123 дугаар ботид буй Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны зохиолуудыг тус тус ашиглав.


Судалгааны арга: Бид сурвалж бичгийн эх, нэр, зохиогч, газар орон, онцлог, агуулга, тайлбар, харьцуулга, хөрвүүлэг, нэрийн хэлхээ зэргийг хамтатган сурвалж бичгийн судлалын аргаар 226 боть Монгол шунхан судар, түүний 118-123 дугаар ботид буй Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны зохиолуудаас судалгааны ажлынхаа зорилгодоо нийцүүлэн зохиогчийнх нь төрсөн болон амьдарч байсан цаг хугацаагаар хамгийн эрт үеэс нь эхлэн эрэмбэлэн судалгааг хийж гүйцэтгэв. Түүнчлэн магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар 226 боть Монгол шунхан судар, түүний 118-123 дугаар ботид буй Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны зохиолуудад байгаа мэдээллийг төрөлжүүлэн жагсааж, тэдгээрийг тодорхойлсон хэсгийг судлав. Магадлан жагсаах арга нь мэдээллийг төрөлжүүлж ангилахад хялбар, өгөгдөл цуглуулахад хялбар, эхний шатны үнэлгээ өгөхөд тохиромжтой, төлөвлөсөн ажлаа урьдчилан харах, цахим санд оруулахад зохимжтой байдаг арга юм.

Үр дүн: Ганжуурын түүвэр судалгаа Монголд VIII зууны үеэс эхэлж хийгдсэн гэж судлаачид тэмдэглэгдсэн байдаг. Үүний дараа Хубилай хааны ач хүү буюу Аюурбарбад (Буянт) хэмээх хаан (1285-1320) XIV зууны үед хааны зарлиг буулган Төвөдийн Нартан хийдэд бүтээлгэсэн Нартан барын Ганжуурыг бүтээсэн. Алтан ургийн сүүлчийн хаан Лигдэн хутагт (1592-1636)-ын зарлигаар Гунгаа-Одсэр тэргүүтэй эрдэмтэд, орчуулагч нар Ганжуурыг 1628-1629 онд бүрэн эхээр нь орчуулжээ. Ганжуурын тайлбар болох Данжуурыг Тэнгэр тэтгэгч хааны (1711-1799) үед Жанжаа хутагт Ролбийдорж удирдан Ширээт хутагт Лувсандамбийням тэргүүтэй монголын 200 орчим эрдэмтэн гүүш нар төвөд хэлнээс монгол хэлээр 1741-1742 онд орчуулан, 1742-1749 оны хооронд 226 боть болгон модон бараар Бээжин хотод хэвлэжээ[2]. Монгол Ганжуур, Данжуур нь бүтнээр болон хэсэг бусаар БНХАУ-ын Бээжин, ӨМӨЗО-ны Номын сан, Францын Парис, АНУ-ын Конгрессын номын сан зэрэгт хадгалагдаж байна. 1742-1749 оны хооронд орчуулсан Монгол Данжуураас хойш 250 гаруй жил болоход одоогоор гурван бүтэн эх хувь байгаагаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Номын сан, Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын сан, Монгол Улсын Үндэсний номын санд тус тус хадгалагдаж байна [3].

Монгол Данжуурыг дотоод гадаадын судлаачид ихээхэн сонирхон судалсаар иржээ. Судлаач Ц.Дамдинсүрэн, Ш.Бира, В.Хайссиг, Логеш Чандра, С.Сэцэнбилиг, Д.Цэрэнсодном нар, мөн анагаах ухааны бүтээлүүдийн талаар судлаач Б.Нарсу, Б.Жигмэд, Ш.Болд нар судалгааны өгүүллүүд хэвлүүлжээ[3]. Ялангуяа судлаач Л.Хүрэлбаатар "Судар шаштирын билиг" номондоо Ганжуур, Данжуурын талаар маш нухацтай, баримттай өгүүлсэн байдаг[4].

Монгол Данжуурын гарчгийг 1920 онд Шагж гуай, 1950-аад оны үед Ц.Дорж, 1964, 1974 онд Б.Ринчен гуай нар тус тус хийж хэвлүүлсэнээс гадна БНХАУ-ын ӨМӨЗО-д хадгалагдаж байгаа Монгол Ганжуур, Данжуурын гарчгийг С.Сэцэнбилиг хийж 2003 онд хоёр ботиор хэвлүүлсэн барримт байна[5].

Данжуур бол Бурхан багшийн номлосон гурван сав, аймаг ба дөрвөн дандарын утгыг тайлан зохиосон Энэтхэгийн мэргэдийн тайлбар шашдируудаас голлон бүтсэн. Тухайлбал, дотоод ухаан, нотлох ухаан, дуун ухаан, тэжээх ухаан, урлах ухаан зэрэг их таван ухаан хийгээд зохист аялгуу, холбож найруулах, илт өгүүлэх, дуурайн бүжих, одон зурхай зэрэг бага таван ухааны зохиолуудыг төвөд хэлээр орчуулан Данжуур хэмээн нэрлэжээ. Данжуур гэдэг нь "Шашдирын орчуулга" гэсэн төвөд үг юм. Бурхан багшийн шавь нар ба дараа үеийн Энэтхэгийн мэргэдийн зохиолыг "шашдир" хэмээн нэрлэж Бурхан багшийн зарлигийн номууд болох Ганжуураас ялган тодорхойлжээ. Данжуурыг дотор нь "Дандарын тайлбар" 86 боть, "Судрын тайлбар" 136 боть гэж хоёр хуваан үздэг. Монгол данжуурт нийт 226 боть зохиол бий [6,7] (Зураг 1).



Зураг 1. Монгол Данжуур. Зандан номын хавтасны дотор шар даавуунд ороож, хоёр модон жаазаар дарсан Монгол Данжуур[8]

Судрын тайлбарын 118-123 дугаар ботид анагаах ухааны 8 зохиол байна[9]. Эдгээр ботиос 118-119 дүгээр ботийн 715 хүртэлхийг Монгол хэлээр Халхын зүүн хошууны гүүш, да лам, маарамба, гэлэн Ишгалсан орчуулжээ. Жич бас Жин зу са (Jin zhu sa) хийдийн тэргүүн лам Билгийн далай болон Урад гүүш Эрдэмийнгэрэл хоёул давтан ариутган найруулаад сударт оршуулсан байна.

119 дүгээр ботийн үргэлжлэлийг Үзэмчин Цэвдэнбэйлийн хошууны гүүш Лувсанпунцаг орчуулсан байна.

120 дугаар ботийг Үзэмчин Цэвдэнбэйлийн хошууны тал хэлт гүүш хэмээх гэвш Гэлэглувсандаш монголчилон орчуулсан байна.

121, 122 дугаар ботиудыг Долоон нуурын Шан ин си (Shan yin si) сүмийн Түмэд гүүш Лувсангэндэн орчуулсан байна.

123 дугаар ботийн анагаах ухаантай холбоотой жижиг ном, урлахуй ухааны аймгийг буюу дууны найрлага хүртэлхийг Шулуун шарын Цахар хошууны Хутгийг мандуулагч сүмийн тэргүүн лам, гүүш Жамьяанданпил Монгол хэлээр тус тус орчуулжээ.


Монгол Данжуурын 118-123 дугаар ботид байгаа анагаах ухааны 8 зохиол:

1. (4855) Зуун найралт (118-1) 2 до-14 дэ
2. (4856) Амьдруулагч эмийн судар (118-3) 14 дэ-20 до
3. (4857) Ава эмийн зан үйл (118-3) 21 дэ- 22 до
4. (4858) Найман гишүүнтийн зүрхний хураасан нэрт (118-4) 23 дэ-527 до
5. (4859) Найман гишүүнтийн зүрхэн хэмээх эм, заслын номлол (118-5) 527 до-119-р боть, 715 до
6. (4860) Эм, заслын найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар үг, утгын сарны гэрэл хэмээх оршивой (120-1) 2 до-121-р боть, 476 до
7. (4861) Эм, заслын найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар эмийн нэрийн зүйл хэмээх оршивой (122-1) 476 до-519 дэ
8. (4862) Хамгийн эрхт шим авахуй хамаг өвчнийг дараад биеийн хүчийг дэлгэрүүлэгч хэмээгдэхүй. (123-1) 2 до-3 до[10]

Монгол Данжуурын доторх анагаах ухааны бусад бүтээлүүд: Монгол Данжуурын 118-123 дугаар ботид байгаа Аюурведийн анагаах ухааны 8 зохиолоос гадна зарим судлаачид “Судрын тайлбар”-т анагаах ухааны дараах бэсрэг зохиолууд байгааг олж тогтоожээ. Үүнд:

1. Гаврын эрхтэн буурсан хийгээд өвчнийг анагаах ба хагацсаныг арилгагч хэмээх
2. Өвчний хорыг эдгээх арга
3. Хий лүүгээ өвчнийг шинжих
4. Хий судал тэргүүтний бясалгал
5. Хулгана яр өвчний бэлгэ чанар
6. Энэтхэгийн орны пахай эмч, данада газрын эм заслын утга оршивой
7. Эм заслын хэрэгтэйг бүтээсэн хэмээх зэрэг судрууд байна[11].

Монгол Улсын Үндэсний номын сангийн “Монгол судлал, гар бичмэл номын сан хөмрөг”-т 21 мянга орчим гар бичмэл, барын ном, “Төвөд номын сан хөмрөг”-т монгол, төвөд эрдэмтэн мэргэдийн бүтээсэн 1.5 сая орчим ном судар, “Дорно дахины ном, хэвлэлийн сан хөмрөг”-т 100 гаруй мянган, нийт гурван сая гаруй ховор чухал ном, судар хадгалагдаж байна[12]. Эдгээрээс Монгол шунхан Данжуурыг Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 241 дүгээр тогтоолоор Монгол Данжуурыг Монгол Улсын түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад, 2011 онд ЮНЕСКО-ийн “Дэлхийн Дурсамж” хөтөлбөрийн олон улсын баримтат өвийн жагсаалтад тус тус бүртгэсэн байна (Зураг 2)[13].


United Nations Educational, Scientific and Cultural Organization

Certifies the inscription of

Mongolian Tanjur

National Library of Mongolia

Ulaanbaatar — Mongolia

On

the Memory of the World International Register

Date 25 May 2011

Irina Bokova

Director-General, UNESCO

Зураг 2. Монгол Данжуур гэрчилгээ. Монгол Данжуурыг 2011 онд ЮНЕСКО-ийн “Дэлхийн Дурсамж” хөтөлбөрийн олон улсын баримтат өвд бүртгэсэн гэрчилгээ

Монгол Данжуур судлал нь барууны орнуудад бусад буддын уламжлалтай улсуудтай харьцуулахад ихэд орой эхэлсэн боловч эрдэмтдийн сонирхол татаж эхэлсэн нь сайшаалтай юм[14]. Гэхдээ манай улсад Монгол Данжуурын доторх Энэтхэгийн Аюурведийн анагаах ухааны зохиолуудын судалгаа харьцангуй бага, эхлэл төдий байна.

Хэлцэмж: XVIII зууны үед Монголын нийгмийн мэдлэг, ухааны салбар бүрт сэтгэлгээний томоохон дэвшилтүүд гарч Буддын шашны их, бага таван ухааны судар, номууд Монгол Данжуурын орчуулгаар дамжин Монголын аймаг, хошуудын сүм, хийд, хурлын газруудад судлагдан, засал, уншлагад хэрэглэгдэж байжээ. Чухамдаа XVIII зуун бол Монгол Данжуурын доторх анагаах ухааны 8 зохиол нэн ялангуяа “Найман гишүүнтийн зүрхний хураасан нэрт” болон “Эм, заслын найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар үг, утгын сарны гэрэл хэмээх оршивой” бүтээлд үндэслэсэн “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн урсгалаар онол, арга зүйн гол удирдлагаа болгосон Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийн алтан үеийн эхлэл бүрэн тавигдсан гэж зоригтой хэлж болно[15]. “Анагаах ухааны дөрвөн үндэс” ном нь Монголын анагаах ухааны хөгжилд томоохон эргэлт гаргаж сургалт, судалгаа, эмнэлгийн тусламжийн бүхэл бүтэн тогтолцоо бүрдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. Энэхүү тогтолцоо нь 2 үндсэн хэсэгт хуваагдаж байжээ. Нэг нь хөдөө орон нутгийн, нөгөө нь хүрээ суурин газрын гэж хуваан үзэж болно[16]. Харин эмнэлгийн тусламжийг үзүүлдэг эмч нарыг Мамба дацанд системтэй бэлтгэдэг байжээ. “Анагаах ухааны дөрвөн үндэс” түүний тайлбар зохиолгүйгээр Мамба дацан бий болох үндэс алга байна. Иймээс Энэтхэгийн Аюурведын анагаах ухаанаас тодруулбал “Найман гишүүнтийн зүрхэн хураангуй”, “Эм, заслын найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар үг, утгын сарны гэрэл хэмээх оршивой”, “Эм заслын саран хаан” зохиолуудаас эх үүсвэрээ авсан “Анагаах ухааны дөрвөн үндэс” түүний төвөд тайлбарууд XVII-XIX зууны Монголын уламжлалт анагаах ухааны үнэ цэнтэй бүтээлүүд болсон байна. Бидний ойлгож байгаагаар “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн урсгалаар онол, арга зүйн гол удирдлагаа болгосон Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийн томоохон хэсэг мамба дацан өөрийн өвөрмөц дэг жаягаа алхам бүр шинэчилсээр XXI зуунд золгож иржээ. Гагцхүү эмч бэлтгэж ирсэн хуучин сургуулийн шинжлэх ухааны үндэстэй хэсгийг нь судлан тогтоож, улам цаашид хөгжүүлэх явдал чухал байсаар байна.

Дүгнэлт: “Монгол Данжуур”-ын Судрын тайлбарын 118-123 дугаар ботид анагаах ухааны 8 зохиол байгааг тодруулан, нэр, ботийн дугаар болон хуудасны тоог дараах байдлаар тогтоов. Үүнд: 1. (4855) Зуун найралт (118-1) 2 до-14 дэ, 2. (4856) Амьдруулагч эмийн судар, (118-3) 14 дэ-20 до, 3. (4857) Ава эмийн зан үйл (118-3) 21 дэ- 22 до, 4. (4858) Найман гишүүнтийн зүрхний хураасан нэрт (118-4) 23 дэ-527 до, 5. (4859) Найман гишүүнтийн зүрхэн хэмээх эм, заслын номлол (118-5) 527 до-119-р боть, 715 до, 6. (4860) Эм, заслын найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар үг, утгын сарны гэрэл хэмээх оршивой (120-1) 2 до-121-р боть, 476 до, 7. (4861) Эм, заслын найман гишүүнтийн зүрхний тийн тайлбар эмийн нэрийн зүйл хэмээх оршивой (122-1) 476 до-519 дэ, 8. (4862) Хамгийн эрхт шим авахуй хамаг өвчнийг дараад биеийн хүчийг дэлгэрүүлэгч хэмээгдэхүй. (123-1) 2 до-3 до гэсэн зохиолууд байв.

Ном зүй:

1. *Монгол Данжуур. Дэлхийн баримтат өвийн жагсаалтад бүртгэгдсэн өв. 2011. https://mongoluv. mn/mn/Intangible/UnescoIchDetails. Хандалт хийсэн 2024.10.03*
2. *Хүрэлбаатар Л. Судар шашдирын билиг. УБ, 2002, х.75*
3. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, х.224*
4. *Хүрэлбаатар Л. Судар шашдирын билиг. УБ, 2002, х.71-81*
5. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, х.225*
6. *Монгол Ганжуур, Данжуурын гарчиг. Дээд. Улсын бар хэвлэлийн хороо. 2002. х.14,16*
7. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, х.225*
8. *Mongolian Tanjur. https://www.unesco.org/en/memory-world/mongolian-tanjur. Хандалт хийсэн 2024.10.04*
9. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, х.226-227*
10. *Монгол Ганжуур, Данжуурын гарчиг. Дээд. Улсын бар хэвлэлийн хороо. 2002. х.775-783*
11. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, х.230*
12. *Үндэсний бүртгэл. https://barimtatuv.mongoluv.mn/National-Register. Хандалт хийсэн 2024.11.04*
13. *Mongolian Tanjur. https://www.unesco.org/en/memory-world/mongolian-tanjur. Хандалт хийсэн 2024.10.04*
14. *Монгол шунхан Данжуур. https://barimtatuv.mongoluv.mn/Mongolia-Documentary-Heritage. Хандалт хийсэн 2024.10.05*
15. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. Анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэгэн сэдэвт зохиол. УБ, 2005*
16. *Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2006, х.179*

The clarifying Ayurvedic medical books in the “Mongolian Tanjur”

Tudevdagva L[1], Gerelmaa B[2], Shagdarsuren D[1], Bold Sh[1,2]

[1]Mongolian University of Pharmaceutical Sciences
[2]“Ach” Medical University
E-mail: ltudevdagva@gmail.com, Tel: +976-99949345

Background: “Tanjur” is the greatest sutra written on thick Chinese muutuu paper with red nature dust paint size 22,7 x 71,8 cm and has 107839 pages. It is the largest collection of ten great and small sciences (philosophy, technology, logic, medicine, philology, astrology, model dance, poetics, Abhidarma, and composition) created by ancient Indian and Tibetan scientists and panditas.
The Mongolian dust paint printed Tanjur had been translated from Tibetan into Mongolian by over 200 translators under the supervision of reincarnated Janjaa Rolbiidorj and Shireet Luvsandambiinyam between 1741 and 1742 and had been printed in Beijing between 1742 and 1749.
Aim: To describe Indian Ayurvedic medical texts in the Mongolian Danjuur, which are stored in the National Library of Mongolia, by determining the names, volume numbers, and page numbers, and clarifying the Mongolian translators.
Materials and Methods: To print “Mongolian Tanjur” from blocks, 2160.9 ounces of silver were used. The “Mongolian Tanjur” contains 8 Indian Ayurvedic medical books.
Results: As a result of this research, we have briefly explained each of the 8 Ayurvedic medical books. Namely: 1. “One Hundred Medical Preparations” composed by Nagarjuna Acharya, 2. “Medical Advice for Longevity,” composed by Nagarjuna Acharya, 3. “Ritual Ava Medicine,” composed by Nagarjuna Acharya, 4. “Essence of Eight Branches,” written by master Vagbhata, 5. “An Explanation of Medical Practices called “The Essence of the Eight Branches” written by master Vagbhata, 6. “A Commentary on the Essence of the Eight Branches called Rays of Moonlight on the Meaning of the Words” written by the Kashmiri Candranandana, 7. “Lexicon of Medical Terms from the Commentary on the Essence of Eight Branches” written by the Kashmiri Candranandana and 8. “A powerful healer to treats all diseases and promotes physical strength,” written by Sivadasa.
Conclusion: Ayurveda is perceived as one of the most ancient and well-documented systems of medicine, equally relevant in modern times. Its holistic approach, whether for healthy individuals or diseased ones, remains unparalleled. Prevention of disease and promotion of health are the main objectives of Ayurveda. Ayurveda is an ancient medicine system of the Indian subcontinent. It is said to have originated in India about 5000 years back. The word Ayurveda is a conjugation of two Sanskrit words, “Ayus,” meaning “Life,” and “Veda,” meaning “Science,” thus, it literally means the ‘science of life. Unlike other medicinal systems, Ayurveda focuses more on healthy living than the treatment of diseases.

Keywords: Tanjur, Medical books, Collection